



ИНД-100

Иргэний Нисэхийн Багц Дүрэм

Аюулгүй байдлын удирдлага

Иргэний нисэхийн ерөнхий газар

ДҮРМИЙН ТАЙЛБАР

Шинээр гарч буй ИНД-100-ийн зорилго нь иргэний нисэхийн байгууллагуудад үр дүнтэй Аюулгүй байдлын соёлыг нэвтрүүлж, хэвшүүлэх замаар Монгол Улсын нисэхийн аюулгүй байдлын үзүүлэлтийг сайжруулах болон Монгол Улсын нэгдэн орсон Олон Улсын Иргэний нисэхийн тухай Конвенцийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлж байгааг бататгахад оршино.

Энэ Дүрэм нь Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан ИНД-100-ийн цахим хувилбар бөгөөд зөвхөн ишлэл хийх зорилгоор хэрэглэнэ. Хүчин төгөлдөр ИНД-100, түүний нэмэлт, өөрчлөлтийн хуулбарыг ИНЕГ-аас, эсхүл www.mcaa.gov.mn веб сайтаас татаж авах боломжтой.

Мэдээлэл

Гишүүн улсуудын иргэний нисэхийн Дүрмийг сайжруулах замаар иргэний нисэхийн салбарт нэгдсэн нэг Дүрмийн зохицуулалтад шилжих Олон улсын иргэний нисэхийн байгууллагын 1992 оны 29-р чуулганы А29-3 тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор, Монгол Улс болон Шинэ Зеланд улсын ИНЕГ-ын хооронд 1999 оны 5 дугаар сарын 6-нд байгуулсан “Техникийн Хамтын Ажиллагааны Санамж Бичиг”-ийг үндэслэн Монгол Улсын Иргэний нисэхийн энэхүү багц Дүрмийг боловсруулсан.

Өөрчлөлтийн түүх

Анхны боловсруулалт

Хүчин төгөлдөр огноо

2018 оны ... сарын ...

Тэмдэглэл: ИНД-100-ийн анхны боловсруулалтыг англи болон монгол хэл дээр, NZ Part 100 A.0-д үндэслэн боловсруулсан болно.

Гарчиг

100.1. Хамрах хүрээ.....	5
100.3. Аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо	5

100.1. Хамрах хүрээ

Энэ Дүрэм нь, Иргэний нисэхийн дүрмээр аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог бий болгох, хэрэгжүүлэх болон хадгалахыг шаардсан байгууллагад хамаарна.

100.3. Аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо

(a) Энэ Дүрэмд хамаарах байгууллага нь дараах ажиллагааг багтаасан Аюулгүй байдлын удирдлагын тогтолцоотой байх үүрэгтэй:

- (1) Аюулгүй байдлын удирдлагын тогтолцоонд суурилсан Аюулгүй байдлын бодлого;
- (2) нисэхийн аюулгүй байдалд учрах аюулыг олж тогтоох, тухайн холбогдох эрсдлийг үнэлэх болон удирдах эрсдэлийн удирдлагын үйл явц;
- (3) дараах шаардлагыг бататгах аюулгүй байдлын баталгаажуулалтын арга хэмжээ:
 - (i) аюул, зөрчил болон ослыг дотооддоо мэдээлэх, түүнд дүн шинжилгээ хийх, дахин давтагдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авдаг байхыг;
 - (ii) нисэхийн аюулгүй байдлыг сайжруулах зорилтуудыг тогтоох ба эдгээр зорилтуудын биелэлтийг хэмжиж дүгнэдэг байхыг;
 - (iii) дотоод аудит хийх болон Аюулгүй байдлын удирдлагын тогтолцоонд тогтмол үнэлгээ хийх ажиллагааг багтаасан чанар баталгаажуулалтын хөтөлбөртэй байхыг.
- (4) аюулгүй байдлын үүрэг хариуцлагаа бүрэн хэрэгжүүлэх ур чадвартай болохыг бататгах ажилтнуудын сургалт.

(b) Тухайн байгууллага нь Аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог бий болгох, хадгалахад шаардлагатай бүх үйл явцыг баримтжуулсан байх үүрэгтэй.

(c) Тухайн байгууллагын Аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо нь байгууллагын хэмжээ, үйл ажиллагааны мөн чанар болон тухайн байгууллагын гүйцэтгэж байгаа тухайн ажиллагааны төвөгшил, байгууллагын үйл ажиллагаатай салшгүй холбоотой аюул болон холбогдох эрсдэлд тохирсон байх шаардлагатай.

--oOo--